

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/153/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/24
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ц.АРИУНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Б/12 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай" тушаалаар тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, үндсэн хөрөнгийн тооллогыг гүйцэтгэсэн боловч үр дүнг хэлэлцэж баталгаажуулаагүй, 53,314.9 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 83 нэр төрлийн 76,343.8 мянган төгрөгийн биет хөрөнгө, 1 нэр төрлийн 50.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 12 харилцагч байгууллагын 43,095.3 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/, мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх

анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх", "Оршин байх", "Тасалбар болголт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 67,271.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 5,315.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95,8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Arkhib/Alban bichig 2023/ A4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,188,017.36</u>	<u>63,597,964.47</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,700.00	10,264,820.20
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,700.00	10,264,820.20
3121	Төгрөг	1,700.00	10,264,820.20
31211	Төрийн сангийн харилцах	1,700.00	10,264,820.20
33	АВЛАГА	291,980.00	00.00
335	Бусад авлага	291,980.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	291,980.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,894,337.36	53,333,144.27
351	Түүхий эд материал	11,341,883.46	28,902,044.37
35130	Эм боох материал	11,341,883.46	28,902,044.37
354	Хангамжийн материал	20,552,453.90	24,431,099.90
35410	Бичиг хэргийн материал	60,000.00	268,600.00
35420	Аж ахуйн материал	10,898,444.00	14,512,630.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,994,900.00	1,754,600.00
35450	Барилгын засварын материал	1,662,005.00	1,662,005.00
35460	Хүнсний материал	295,000.00	4,591,160.00
35470	Бусад хангамжийн материал	1,642,104.90	1,642,104.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>741,932,500.52</u>	<u>775,851,603.32</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	741,932,500.52	775,851,603.32
392	Биет хөрөнгө	740,704,500.52	774,623,603.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	673,123,432.78	673,123,432.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-41,600,642.50	-61,706,720.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	77,010,084.00	101,540,084.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55,716,221.01	-59,507,531.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,374,578.00	135,576,128.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,833,395.44	-25,804,183.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,907,020.50	11,411,825.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,252,850.05	-7,980,572.46
39209	Зам, гүүрний байгууламж	28,037,615.33	28,037,615.33
39210	Хуримтлагдсан элэгдэл	-23,198,379.16	-24,244,700.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,071,600.00	7,421,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,218,341.93	-3,243,375.20
393	Биет бус хөрөнгө	1,228,000.00	1,228,000.00
39301	Программ хангамж	50,000.00	50,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-50,000.00	-50,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,228,000.00	1,228,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>774,120,517.88</u>	<u>839,449,567.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9,859,023.90</u>	<u>2,493,761.78</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,859,023.90	2,493,761.78
413	Өглөг	9,859,023.90	2,493,761.78
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,859,023.90	2,493,761.78

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>764,261,493.98</u>	<u>836,955,806.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	764,261,493.98	836,955,806.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	233,383,976.31	233,383,976.31
51101	Өмч: - төрийн	233,383,976.31	233,383,976.31
512	Хуримтлагдсан үр дүн	27,955,900.41	100,650,212.44
51210	Өмнөх үеийн үр дүн	27,955,900.41	27,955,900.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	72,694,312.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	502,921,617.26	502,921,617.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>774,120,517.88</u>	<u>839,449,567.79</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	568,976,964.96	490,074,614.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	171,201,669.96	87,003,193.86
120	Нийтлэг татварын бус орлого	171,201,669.96	87,003,193.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	171,201,669.96	87,003,193.86
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	171,201,669.96	87,003,193.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,270,695.00	403,071,421.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,504,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,424,155.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,424,155.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,505,200.00	403,071,421.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,505,200.00	403,071,421.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,341,340.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,341,340.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	433,540,792.99	417,378,602.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,540,792.99	417,378,602.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,221,206.99	417,378,602.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,399,163.00	253,431,645.61
210101	Үндсэн цалин	160,766,465.23	174,641,492.99
210102	Нэмэгдэл	72,372,497.77	63,011,640.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,998,000.00	3,958,644.09
210104	Урамшуулал	24,262,200.00	11,819,868.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,566,455.00	33,401,182.97
210201	Тэтгэврийн даатгал	23,543,514.77	19,718,310.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,511,240.23	2,596,235.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,003,100.00	2,160,431.06
210204	Ажилгүйдлийн даатгал	500,800.00	870,007.13
210205	Эрүүл мэндийн даатгал	5,007,800.00	8,056,198.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,210,614.00	00.00
210301	Гэрэл, цахилгаан	1,703,584.00	00.00
210302	Түлш, халаалт	33,432,030.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	75,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,374,780.00	37,033,464.00
210401	Бичиг хэрэг	2,807,000.00	2,429,600.00
210402	Тээвэр, шатахуун	20,730,000.00	25,745,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	3,939,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,937,780.00	4,919,114.00
2105	Нормативт зардал	28,154,350.83	41,608,657.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,299,820.83	21,564,951.33
210502	Хоол, хүнс	6,854,530.00	9,280,560.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	10,763,146.10

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135,000.00	10,905,000.00
210604	Урсгал засвар	135,000.00	10,905,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,245,400.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,245,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,380,844.16	39,753,252.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,018,555.00	1,086,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,362,289.16	38,667,252.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,586.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	319,586.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>135,436,171.97</u>	<u>72,696,012.03</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	78,464,479.76	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	78,464,479.76	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-78,464,479.76	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>56,971,692.21</u>	<u>72,696,012.03</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	397,775,295.00	404,390,121.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	397,775,295.00	404,390,121.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,504,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,424,155.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,424,155.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,505,200.00	404,390,121.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,505,200.00	404,390,121.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,341,340.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,341,340.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	397,208,195.00	394,125,300.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,208,195.00	394,125,300.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,888,609.00	394,125,300.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,873,465.23	254,904,428.58
210101	Үндсэн цалин	160,766,465.23	169,213,736.29
210102	Нэмэгдэл	59,846,800.00	64,490,823.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,998,000.00	4,737,880.00
210104	Урамшуулал	24,262,200.00	16,461,989.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,559,114.77	33,247,100.00
210201	Тэтгэврийн даатгал	23,543,514.77	23,036,245.94
210202	Тэтгэмжийн даатгал	2,503,900.00	2,397,730.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,003,100.00	2,151,247.49
210204	Ажилгүйдлийн даатгал	500,800.00	538,086.14
210205	Эрүүл мэндийн даатгал	5,007,800.00	5,123,789.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,035,614.00	720,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,553,584.00	720,000.00
210302	Түлш, халаалт	33,432,030.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,829,100.00	32,250,000.00
210401	Бичиг хэрэг	1,512,100.00	2,024,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,730,000.00	25,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,000.00	1,975,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	3,000,000.00
2105	Нормативт зардал	17,184,260.00	29,724,733.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,531,350.00	18,924,733.22
210502	Хоол, хүнс	5,652,910.00	10,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	7,020,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	3,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,750,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	1,150,000.00	1,020,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,245,400.00

210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,245,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,907,055.00	35,013,339.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,907,055.00	35,013,339.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,586.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
		319,586.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	319,586.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>567,100.00</u>	<u>10,264,820.20</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	565,400.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	565,400.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	565,400.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	565,400.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-565,400.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,700.00	10,264,820.20
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,700.00	10,264,820.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	(29,015,791.80)	707,289,801.77
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	(29,015,791.80)	707,289,801.77
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
7	Тайлант үеийн үр дүн			56,971,692.21	56,971,692.21
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	27,955,900.41	764,261,493.98
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	27,955,900.41	764,261,493.98
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	27,954,200.41	764,259,793.98
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		00.00	00.00	00.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		00.00	00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		00.00	00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		00.00	00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн		00.00	72,696,012.03	72,696,012.03
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	100,650,212.44	836,955,806.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	422,275,100.00	406,605,687.80	15,669,412.20	96.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,275,100.00	406,605,687.80	15,669,412.20	96.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,275,100.00	406,605,687.80	15,669,412.20	96.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,149,400.00	256,314,428.58	11,834,971.42	95.59
210101	Үндсэн цалин	172,766,600.00	166,652,335.69	6,114,264.31	96.46
210102	Нэмэгдэл	60,584,600.00	61,759,450.85	(1,174,850.85)	101.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	4,424,880.00	111,120.00	97.55
210104	Урамшуулал	30,262,200.00	23,477,762.04	6,784,437.96	77.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,424,500.00	33,424,500.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,728,600.00	22,969,845.94	(241,245.94)	101.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,674,000.00	2,702,934.60	(28,934.60)	101.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,139,300.00	2,162,647.49	(23,347.49)	101.09
210204	Ажилгүйдлийн даатгал	534,800.00	540,886.14	(6,086.14)	101.14
210205	Эрүүл мэндийн даатгал	5,347,800.00	5,048,185.83	299,614.17	94.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,615,500.00	40,026,848.00	588,652.00	98.55
210301	Гэрэл, цахилгаан	4,815,500.00	4,714,374.00	101,126.00	97.90
210302	Түлш, халаалт	35,500,000.00	35,012,474.00	487,526.00	98.63
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,250,000.00	32,250,000.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,024,500.00	(24,500.00)	101.23
210402	Тээвэр, шатахуун	25,250,000.00	25,250,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,975,500.00	24,500.00	98.78
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	27,300,000.00	24,054,211.22	3,245,788.78	88.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,500,000.00	13,254,211.22	3,245,788.78	80.33
210502	Хоол, хүнс	10,800,000.00	10,800,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,170,300.00	8,170,300.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	2,170,300.00	2,170,300.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,245,400.00	1,245,400.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	1,245,400.00	1,245,400.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,120,000.00	11,120,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,120,000.00	11,120,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	422,275,100.00	418,533,949.00	3,741,151.00	99.11
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	14,306,848.00	(14,306,848.00)	-

131001	Улсын төсвөөс санхүүжих	-	14,306,848.00	(14,306,848.00)	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,361,800.00	30,120,841.00	13,240,959.00	69.46
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	43,361,800.00	30,120,841.00	13,240,959.00	69.46
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	376,543,300.00	371,736,260.00	4,807,040.00	98.72
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	376,543,300.00	371,736,260.00	4,807,040.00	98.72
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,370,000.00	2,370,000.00	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,370,000.00	2,370,000.00	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,700.00	(1,700.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,264,820.20	(10,264,820.20)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв нь эрхэм зорилгоо “Бүхний эрүүл мэндийн төлөө хамтдаа зүтгэн, сумын эрүүл мэндийн төвийн стандартын хангалтыг сайжруулан, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх” гэж тодорхойлсон.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/A/118 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам ”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,329.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.7	10,264.8	10,263.1
Авлага	292.0	-	(292.0)
Бараа материал	31,894.3	53,333.1	21,438.8
Үндсэн хөрөнгө	741,932.4	775,851.6	33,919.2
Нийт хөрөнгийн дүн	774,120.4	839,449.5	65,329.1
Өглөг	9,859.0	2,493.8	(7,365.2)
Засгийн газрын хувь оролцоо	233,383.9	233,383.9	-
Хуримтлагдсан үр дүн	27,955.9	100,650.2	72,694.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	502,921.6	502,921.6	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	774,120.4	839,449.5	65,329.1

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,264.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 292.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өмнөх оны авлагыг бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,438.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хандиваар 18,322.4 мянган төгрөгийн эм боох материал үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 33,919.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 67,271.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 5,315.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 7,365.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өглөгийг барагдуулснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 43,361.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 376,543.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 2,370.0 мянган төгрөг, нийт 422,275.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 422,275.1 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 43,361.8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 376,543.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 2,370.0 төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,306.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,120.8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 371,736.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 2,370.0 мянган төгрөг, нийт 418,533.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 406,605.7 мянган төгрөгийг зарцуулж, 10,266.5 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 406,605.7 мянган төгрөг буюу 96,3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 11,834.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 588.7 мянган төгрөг, нормативд зардал 3,245.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	43,361.8	27,947.5	15,414.3	-
1.2	80111-Төрийн байгууллагын тогтмол зардал	-	720.0	(720.0)	-
1.3	80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	223,614.3	216,332.1	7,282.2	96.7
1.4	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	152,929.0	151,220.6	1,708.4	98.9
1.5	83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан	2,370.0	3,740.0	(1,370.0)	157.8
Дүн		422,275.1	399,960.2	22,314.9	94.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх, бараа материалыг зарцуулахдаа эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг ашиглаж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр цахимаар ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 378,663.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,679.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,259.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 11,834.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 588.7 мянган төгрөг, норматив зардал 3,245.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 170 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 158 мэдээллийг хугацаандаа, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын ажил гүйлгээнээс 6,841.5 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээг, нийт 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтаас 4 байгууллагын нийт 54,256.2 мянган төгрөгийн худалдан авалтыг тус тус мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд байршуулах мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт, хуулийн хугацаанд багтаан мэдээлж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 54,997.5 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 633.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 2 албан шаардлагыг хэрэгжүүлэн, 54,363.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Хэрэгжилт 80 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	2	-	100.0
Төлбөрийн акт	2	633.7	2	633.7	100.0
Зөвлөмж	1	54,363.8	-	-	0.0
Нийт дүн	5	54,997.5	4	633.7	80.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 176,862.2 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 129,708.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 47,153.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 129,708.7 мянган төгрөгийн 2 зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Б/12 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай" тушаалаар тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, үндсэн хөрөнгийн тооллогыг гүйцэтгэсэн боловч үр дүнг хэлэлцэж баталгаажуулаагүй, 53,314.9 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/", мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн жилийн эцсийн хөрөнгө, бараа материалын тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн гүйцэтгэж, баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 83 нэр төрлийн 76,343.8 мянган төгрөгийн биет хөрөнгө, 1 нэр төрлийн 50.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 12 харилцагч байгууллагын 43,095.3 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаж байх.

2. Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 80 нэр төрлийн 4,058.1 мянган төгрөгийн эм боох материал /эм, тариа, вакцин/ бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.22-д "Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагдах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг зарцуулахдаа эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг ашиглаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Б/12 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай" тушаалаар тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, үндсэн хөрөнгийн тооллогыг гүйцэтгэсэн боловч үр дүнг хэлэлцэж баталгаажуулаагүй, 53,314.9 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй	1	53,314.9			1	53,314.9					-	-	-	
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 83 нэр төрлийн 76,343.8 мянган төгрөгийн биет хөрөнгө, 1 нэр төрлийн 50.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	76,393.8			1	76,393.8					-	-	-	
Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 12 харилцагч байгууллагын 43,095.3 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй	1	43,095.3					1	43,095.3			-	-	-	
Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 80 нэр төрлийн 4,058.1 мянган төгрөгийн эм боох материал /эм, тариа, вакцин/ бүртгэлтэй	1	4,058.1					1	4,058.1			-	-	-	
Дүн	1	176,862.2			2	129,708.7	2	47,153.5			-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 158 мэдээллийг хугацаандаа, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын ажил гүйлгээнээс 6,841.5 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээг, нийт 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтаас 4 байгууллагын нийт 54,256.2 мянган төгрөгийн худалдан авалтыг тус тус мэдээлээгүй	1	61,097.7	-	-	-	-	-	-	1	61,097.7
Дүн	1	61,097.7	-	-	-	-	-	-	1	61,097.7

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn